



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 23

Эрдэнэт

Ээлжит хуралдаан  
зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит IV хуралдааныг 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1.Аймгийн боловсролын салбарыг 2021-2024 онд хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай.

2.Жагсаалт батлах тухай.

Хоёр.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит IV хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Гурав.Аймгийн ИТХ-ын Ээлжит IV хуралдааныг бэлтгэл хангаж хуралдуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Д.Мөнхбат/-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ